



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар Н/140

Дадал сум

**Засаг даргын нөөц сангаас зардал
гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ардын Хувьсгалын 104 жилийн ой, Дадал сум байгуулагдсаны 102 жилийн ойн баяр наадмын хурдан морь, аж ахуйн болон хэв журмын салбар комиссын шатахууны зардал болох 1,268,400 (Нэг сая хоёр зуун жаран найман мянга дөрвөн зуу) төгрөг, “ЁОХОР НААДАМ 2025” эвент арга хэмжээнд сумаас буриад сурын харвааг зохион байгуулж хариуцан бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллах мөн сумаа төлөөлөн “Ёохор хатар-2025” бүжгийн уралдаан, “Аялгата буряад хэлэмнэй” уран уншлагын уралдаанд оролцох багийн Батширээт сум руу очиж ирэх шатахуунд 951,440 (Есөн зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун дөч) төгрөг, сумын зам тэгшилгээ хийх шатахууны 1,632,000 (Нэг сая зургаан зуун гучин хоёр мянга) төгрөгийн зардлыг тус тус гарган зарцуулсугай.

2.Нийт зардлын 3,851,840 (Гурван сая найман зуун тавин нэгэн мянга найман зуун дөч) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

01000004 7